



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 508

Улаанбаатар хот

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
дүрэмд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 378 дугаар тогтоол болон 2019 оны 18 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 131 дүгээр тогтоолоор баталсан “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэмд дараах нэмэлт оруулсугай.

1.1.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 1.2, 4.2 дахь хэсгүүдэд “...шилжүүлэн ачих, хадгалах,” гэсний дараа “импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх” гэж, мөн 4.8.3 дахь хэсэгт “... зохих журмын дагуу импортлох,” гэсний дараа “бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх” гэж тус тус нэмсүгэй.

2.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт зохих журмын дагуу бүртгүүлэхийг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Гансүхэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001014